

Зөвшөөрөгдсөн ажил-тусгай нөхцөл

2020 оны 05-р сар

2010 оны 11-р сарын 9-ний өдөр АНУ-ын Нью-Йорк мужид гэрээт ажилтан усан суурьтай химийн зуурмагийн танкны бэхлэгээний тогтоогчийг шинээр гагнаж байсан. Танкны гадна талбайд шатамхай бодисын аюулгүйн хяналт тогтоож, өндөр хэмийн ажил гүйцэтгэхийг зөвшөөрсөн байсан хэдий ч танкны дотор тест хийгдээгүй байсан. Гэнэтийн тэсрэлт үүсэх үед нэг хүн амиа алдаж, нэг хүн 1-р зэргийн түлэгдэл авч, нэг хүн хөнгөн гэмтсэн байна.

Химийн зуурмагт шатамхай бодисын үлдэгдэл агуулагдаж байсан, зуурмагийн танкны холболтыг анзаараагүй, танкны доторх шугам хоолой гоожсон зэрэг хүчин зүйлсийн улмаас шатамхай уур хуримтлагдаж, улмаар өндөр хэмийн ажлаас оч үсэрснээр гал ноцох нөхцөл бүрдсэн аж. (Эх сурвалж: Chemical Safety Board Investigation Report #2011-01-I-NY). Тогтмол давтамжтай хийгддэггүй ажлуудын хувьд “ажлын зөвшөөрөл” шаардлагатай байж болно. “Ажлын зөвшөөрөл” нь ихэвчлэн ажилтан мэдээлэл нөхөж бичих, өөр нэг ажилтан хянаж, гарын үсэг зурах зориулалт бүхий хуудаснуудаас бүрдсэн байдаг.

“Ажлын зөвшөөрөл” шаардлагатай ажлын жишээ: Хязгаарлагдмал орчинд нэвтрэх (CSE), Өндөр хэмийн ажил, Түгжих ба Пайзлах (LOTO), Шугам хоолой/Тоног төхөөрөмж задлах гэх мэт.

Зарим компани стандартын бус ажлуудад (кран зөөх, тохируулах, вакум трак/машин ашиглах, аюулгүйн системүүдийг салгах гэх мэт) “ажлын зөвшөөрөл” ашигладаг. Эдгээр болон бусад “ажлын зөвшөөрөл” шаардлагатай ажлууд нь химийн салбарт түгээмэл тохиолддог ослуудыг учруулдаг.

“Ажлын зөвшөөрөл” нь тухайн ажил хийгдэхийн өмнө, үргэлжлэх хугацаанд ба хийгдсэний дараа холбогдох онцгой аюулуудын талаар бүрэн ойлгож, хянасан эсэхийг магадлан шалгах хуудастай байдаг.

Өмнө – Ажил эхлэхийн ӨМНӨ “ажлын зөвшөөрөл” дээрх бүх шаардлагатай танилцаж, гарын үсэг зурсан байх ёстой.

Үргэлжлэх хугацаанд – Ажлын явцад ямар нэгэн өөрчлөлт гарахгүй байхын тулд тухайн талбайн ажлуудыг хянаж байх шаардлагатай (Хязгаарлагдмал орчны агаар эсвэл шатамхай бодисын түвшин гэх мэт).

Дараа – “Ажлын зөвшөөрөл” олгосон ажлын явцад тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн процесс, бодит нөхцөл байдалд өөрчлөлт орсон бол ажлыг цааш үргэлжлүүлэхийн өмнө нөхцөл байдал хэвийн эсэхийг бататган шалгах ёстой.



Өндөр хэмийн ажлын үед үүссэн онцгой гал, хэт даралттай холбоотой осол

Та мэдэх үү?

Зарим стандартын бус үйл ажиллагааны үед аюулгүйн төхөөрөмжийг салгах, унтраах шаардлагатай байдаг. Тиймээс срдийн дохиоллыг идэвхжүүлээгүй эсвэл аюулгүйн систем байхгүй байж болзошгүй.

Тусгай ажил гүйцэтгэх үед үйлдвэрлэлийн процессын нөхцөл өөрчлөгдөхөд хавхлагууд өөр өөр байрлалд шилжиж болно. Эдгээрийг “ажлын зөвшөөрөл” дээр тэмдэглэх хэрэгтэй.

Гэрээт ажилтнууд “ажлын зөвшөөрөл”-д тусгагдсан ажлыг гүйцэтгэхдээ танай системийн талаар ойлголтгүй байж болзошгүй.

Та юу хийж чадах вэ?

Ямар ажилд “Ажлын зөвшөөрөл” шаардлагатайг мэддэг байх, “ажлын зөвшөөрөл”-ийн журмыг мөрддөг байх хэрэгтэй.

Ажилд бэлдэх эсвэл “ажлын зөвшөөрөл” бөглөх процессыг товчилж буюу дутуу хийж болохгүй. Хэрэв гэрээт ажилчид “ажлын зөвшөөрөл” шаардлагатай ажил гүйцэтгэж байгаа бол ажлын нөхцлийг ойлгосон байх, зөвшөөрөлд тусгагдсан ажлыг бүрэн зөв гүйцэтгэх ёстой.

Ажлыг гүйцэтгэсний дараа ажлын талбайд очиж хэвийн үйл ажиллагааг эхлүүлэхэд бэлэн эсэх, бүх аюулгүйн систем ажиллаж буй эсэхийг баталгаажуулах шаардлагатай.

Хэрэв та “ажлын зөвшөөрөл” шаардлагатай ажилд оролцож байгаа бол үүнд нухацтай хандах хэрэгтэй. Таны болон бусдын амь нас үүнээс хамаарч болно.

“Ажлын зөвшөөрөл”-өөс таны амь нас хамаарч болзошгүй учир нухацтай хандах хэрэгтэй!